



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/ 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/134/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот
2018 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 70442424 Цахим хаяг: tsetsegmaad@audit.gov.mn

Гэрээт аудитор: Б.Цогзолмаа

Утас: 94640011

Цахим хаяг: ttsogzolmaabaterdene@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
	Аудитын тайлан	5
	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
	Шилэн дансны мэдээлэл	9
	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
	Менежментийн захидал	10
	Аудит хийсэн санхүү байдлын тайлан	10
	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Д.АМАРСАНАА ТАНАА

2019.01.31 № 2/06

танай _____-ны № _____ т

Г _____ Г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Халамжийн сангийн Орон нутгийн төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Халамжийн сангийн Орон нутгийн төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүү байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Халамжийн сангийн Орон нутгийн төсвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2518475

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



1 Аудитын тайлан

ОРШИЛ

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/-гийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ХХҮГ-ын даргыг түр орлон гүйцэтгэгч Амарсанаа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/-гийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/-гийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.10-наас 2019.01.30-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.01.31 -ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын Гэрээт аудитор Б.Цогзолмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/ нь 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.07-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/-гийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/ нь Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй, чанар хүртээмжтэй хүргэхэд халамж, асрамжийн үйлчилгээг хуулийн хүрээнд зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог ханган хамтран ажиллах, хувиарлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зөв зарцуулах шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах,

анхан шатны нэгжид ажиллаж байгаа ажилтнуудыг арга зүйн удирдлагаар хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/-гийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Хөдөлмөр эрхлэлт, нийгэм халамжийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлж иргэдийг ажилтай орлоготой болгох
- Нийгэм халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэд болон зорилтод бүлгийн иргэдийн талаар төрөөс баримтлах бодлого шийдвэр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/-гийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/-гийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт,

холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/ санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 45 оноо авсан тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/-гийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “finance” програм хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/-гийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Дунд” гэж үзлээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/-гийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж санал дүгнэлт гаргахад шаардлагатай материаллаг байдлын түвшинг урьдчилсан байдлаар тооцохдоо суурь үзүүлэлтийг үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгох нь зохимжтой гэж үзэв.

Материаллаг байдлын суурийг орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэж байна.

Гүйцэтгэлийн шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй болно. Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/-гийн 2018 оны *Нийт зардал* 8,155,234.9 мянган төгрөг бөгөөд сонгосон суурь үзүүлэлтийг 1 хувиар тооцож, материаллаг байдлын түвшнийг урьдчилсан байдлаар 81552,3 мянган төгрөгөөр тогтоож, Маягт № Б201-ээр баримтжуулан баталгаажуулав.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа зөрчил илрээгүй, залруулга хийгдээгүй болно.

ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

БАЙХГҮЙ

Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/ чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой орон нутгийн санд 2018 онд 8,039,876.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 8,058,701.2 мянган төгрөг буюу 100% хувьтай байна.

Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Мөнх-Эрдэнэ гүйцэтгэж, аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл: Бид Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/-гийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/-гийн 2018 оны жилийн эцсийн Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Тус байгууллагын аудитын тайлангаар менежментийн захидал өгөгдөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	95,065,730.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	95,065,730.00
413	Өглөг	-	95,065,730.00
4136	Бусад өглөг	-	95,065,730.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	95,065,730.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	(95,065,730.00)
51	Засгийн газрын хувь оролцоо	-	(95,065,730.00)
512	Хуримтлагдсан үр дүн	-	(95,065,730.00)
51210	Өмнөх үеийн үр дүн	(8,997,224.18)	(8,997,224.18)
51220	Тайлант үеийн үр дүн	8,997,224.18	(86,068,505.82)

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,780,228,357.82	8,060,169,182.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,543,857.82	20,292,982.79
120	Нийтлэг татварын бус орлого	7,543,857.82	20,292,982.79
120002	Хүүгийн орлого	3,089,307.82	2,487,330.14
120009	Бусад орлого	4,454,550.00	17,805,652.65
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,772,684,500.00	8,039,876,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,772,684,500.00	8,039,876,200.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	7,772,684,500.00	8,039,876,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,771,231,133.64	8,155,234,912.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,771,231,133.64	8,155,234,912.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,767,895,676.00	8,153,766,919.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,767,895,676.00	8,153,766,919.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,293,450.00	5,895,550.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	7,763,602,226.00	8,147,871,369.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,335,457.64	1,467,993.79
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,335,457.64	1,467,993.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,335,457.64	1,467,993.79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8,997,224.18	(95,065,730.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,997,224.18	(95,065,730.00)

СТ-3А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	уйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1	уйл ажиллагааны мөнгөн орлогын дун (1)	7,788,949,545.82	8,085,764,650.79
12	татварын бус орлого	16,265,045.82	45,888,450.79
120	нийтлэг татварын бус орлого	16,265,045.82	45,888,450.79
120002	хүүгийн орлого	3,089,307.82	2,487,330.14
120004	төсөв байгууллагын өөрийн орлого	8,721,188.00	25,595,468.00
1200041	үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,721,188.00	25,595,468.00
120009	бусад орлого	4,454,550.00	17,805,652.65
13	тусламж, санхүүжилтийн орлого	7,772,684,500.00	8,039,876,200.00
1310	улсын төвлөрсөн төсвөөс	7,772,684,500.00	8,039,876,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,772,684,500.00	8,039,876,200.00

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/-гийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	7,788,950,761.64	8,085,764,650.79
21	Урсгал зардал	7,788,950,761.64	8,085,764,650.79
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	11,116,140.00	5,895,550.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,116,140.00	5,895,550.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,293,450.00	5,895,550.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	6,822,690.00	-
213	Урсгал шилжүүлэг	7,777,834,621.64	8,079,869,100.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,774,499,164.00	8,078,401,107.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	7,774,499,164.00	8,078,401,107.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,335,457.64	1,467,993.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,335,457.64	1,467,993.79
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гуйлгээ (3)=(1)-(2)	(1,215.82)	-
8	Нийт цэвэр мөнгөн гуйлгээ (8)=(3)+(6)+(7)	(1,215.82)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,215.82	-

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	-8,997,224.18	0.00	-8,997,224.18
D08	Тайлант үеийн үр дүн			-86,068,505.82		-86,068,505.82
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	-95,065,730.00	0.00	-95,065,730.00

СТ-5А

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,215.82		-
2	нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	7,772,684,500.00	7,772,439,566.00	8,039,876,200.00	8,058,701,189.00
21	урсгал зардал	7,772,684,500.00	7,772,439,566.00	8,039,876,200.00	8,058,701,189.00
213	урсгал шилжүүлэг	7,772,684,500.00	7,772,439,566.00	8,039,876,200.00	8,058,701,189.00
2132	бусад урсгал шилжүүлэг	7,772,684,500.00	7,772,439,566.00	8,039,876,200.00	8,058,701,189.00
213203	нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	7,772,684,500.00	7,772,439,566.00	8,039,876,200.00	8,058,701,189.00

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/-гийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	7,772,684,500.00	7,772,439,566.00	8,039,876,200.00	8,058,701,189.00
1320	орон нутгийн төсвөөс санхүүжих	7,772,684,500.00	7,772,439,566.00	8,039,876,200.00	8,058,701,189.00
132001	орон нутгийн төсвөөс	7,772,684,500.00	7,772,439,566.00	8,039,876,200.00	8,058,701,189.00